



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1/20

Өлгий

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, ЭМСайдын 2024 оны “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийг шинэчлэн батлах тухай” А/320, А/321 дүгээр тушаал, ЭМСайдын албан тушаалын тодорхойлолт батлах тухай 2012 оны 182, 183 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Мейрим” өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт, боловсрол, мэргэжлийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл, эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал хариуцсан мэргэжилтэн,

Гишүүд:

- Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн,
- Хууль эрх зүй, өргөдөл, гомдол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан;

2. Хяналт үнэлгээний дүгнэлтийг Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг удирдлага төлөвлөлт, санхүү, мэдээллийн хэлтсийн даргад даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Анжелика* АНЖЕЛИКА

